



САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ДЭЭД СУРГУУЛЬ  
ЭКОНОМИКС, ЭКОНОМЕТРИКСИЙН ТЭНХИМ

# Мөнгөний бодлогын арга хэлбэрийн шинжилгээ

Удирдагч:

Ц.Батсүх /Ph.D/

Боловсруулсан:


Б.Батхишиг

Б.Номун

Г.Цэрэннадмид

# Үндэслэл

## Эдийн засгийн зарим үзүүлэлтүүд



# Үндэслэл

- 2007 оноос хойш Монголбанк мөнгөний агрегатыг чиглэсэн бодлогоос татгалзаж инфляцийг онилох мөнгөний бодлогыг хэрэгжүүлэхээр зарлан ажиллаж байна.
- Энэхүү бодлогын арга хэлбэр Монгол улсын хувьд хэр тохиромжтой вэ?

# Оршил

- Тус судалгааны ажлаар мөнгөний бодлогын шилжих механизм, арга хэрэгслүүдийн давуу тал болон сул талыг тодруулан, түүн дээр үндэслээд Монгол улс мөнгөний бодлогын ямар арга хэлбэрийг баримталбал тохиромжтой болохыг харьцуулсан судалгааны аргачлалаар тодорхойлохыг зорилоо.
- Үүнийг тодорхойлсноор Монголбанкнаас албан ёсоор зарлаад байгаа инфляцийг онилсон мөнгөний бодлого манай улсад тохирох эсэх, тодорхойлогдох мөнгөний бодлогын урьдач нөхцлийг хэрхэн хангасан талаар санал боловсруулах ач холбогдолтой.

# Агуулга

- Оршил
- Онолын хэсэг
  - Мөнгөний бодлогын зорилго, зорилт
  - Шилжих механизм
  - Мөнгөний бодлогын арга хэлбэрүүд
- Судалгааны хэсэг
  - Олон улсын туршлага
  - Монгол улсын макро эдийн засгийн тойм
  - Урьдач нөхцөл
- Дүгнэлт
- Ашигласан материалын эх сурвалж


# Мөнгөний бодлогын зорилго, зорилт



Эх сурвалж: (Walsh, 2010)

Монголбанкны мөнгөний бодлогын үндсэн чиглэл нь эдийн засаг, ажил эрхлэлтэд үзүүлж болох богино болон дунд хугацаан дахь нөлөөллийг харгалзан үзэх замаар урт хугацааны үнийн тогтвортой байдлыг хангахад оршино

# Шилжих механизм



Эх сурвалж: (Loayza & Hebbel, 2002) •

# МӨНГӨНИЙ БОДЛОГЫН АРГА ХЭЛБЭРҮҮД

- Валютын ханшийг онилсон мөнгөний бодлого
  - Төв банк гадаад валютын зах дээр интервенци хийж валютын эрэлт, нийлүүлэлтэд нөлөөлж ханшийг өөрчлөх болон валютын ханшийн хэлбэлзлийг бууруулах замаар валютын ханшийг зорилтот түвшинд барьдаг.
- Мөнгөний үзүүлэлтийн өсөлтийг онилсон мөнгөний бодлого
  - Үнийн ерөнхий түвшинг тогтвортой байлгахын тулд хугацааны агшин бүрийн мөнгөний үзүүлэлтийн өсөлтийг тогтмол түвшинд байлгах зорилттой мөнгөний бодлого

(Mishkin, 2010)

# МӨНГӨНИЙ БОДЛОГЫН АРГА ХЭЛБЭРҮҮД

- Инфляцийг онилсон мөнгөний бодлого
  - Дунд хугацаанд үнийн ерөнхий түвшинг тогтвортой байлгахын тулд богино хугацааны инфляцийн түвшинг тодорхой хязгаараас илүү гаргахгүй байх зорилт дэвшүүлэн Төв банкны бодлогын хүүгээ өөрчлөх замаар явуулдаг бодлого
- Эцсийн зорилгоо зарладаггүй мөнгөний бодлого
  - Ямар нэгэн зорилго, зорилтыг онцлолгүйгээр макро эдийн засгийн үзүүлэлтүүдийг сайжруулахад чиглэгддэг.

(Mishkin, 2010)

# Олон улсын туршлага

## Аж үйлдвэржсэн орнууд


- Инфляцийг онилох мөнгөний бодлогын тухай ойлголт анх 1989 онд Шинэ Зеландад үүссэн.
- Шинэ Зеланд (1990),
- Канад (1991),
- Их Британи (1992),
- Израйл (1992),
- Швед (1993),
- Австрали (1994),
- Швейцарь (2000),

## Шилжилтийн эдийн засаг

- Чили (1991),
- Бразил (1999),
- Солонгос (1998),
- Тайланд (2000),
- Өмнөд Африк (2000) зэрэг дэлхийн зах зээлд шинээр гарч ирж байгаа (emerging market) орнууд
- Бүгд Найрамдах Чех Улс (1998),
- Польш (1998),
- Унгар (2001),
- Румын (2005) зэрэг зарим шилжилтийн эдийн засагтай орнууд хэрэгжүүлжээ


Эх сурвалж. (Энхзаяа, 2008)

# Шинэ Зеланд улс



Эх сурвалж: (Brooke, Collins and Smith, 1998)

# Швед улс




Эх сурвалж: Шведийн Үндэсний Эдийн Засгийн Судалгаа, Статистикийн Институци

# Канад улс

- Канадын Төв Банкны удирдлага Канадын эдийн засгийн бүтцийг хөгжүүлсэн.
  - Тодорхой зорилготой байх
  - Мөнгөний бодлогын шилжих механизмын тодорхой төсөөлөлтэй байх
  - Цаашид инфляцийн зорилтот түвшинд хүрэхэд аль сувгийг сонгохыг шийдвэрлэх
  - Таамаглал хийх загваруудыг жижиг ба энгийнээр хийх, ялангуяа эхэлж байхад
  - Улирал төлөвлөлтийн өгөгдөл дээр идэвхтэй хяналт хийх
  - Загварын үр дүнд алдааны шинжилгээг нэмж тусгах

# Чили улс



Эх сурвалж: Чилийн Төв Банк

# Чех улс

- Чехийн хувьд инфляцийг онилох бодлогыг хэрэгжүүлэх гол урьдчилсан нөхцөлүүд бүрдсэн байсан ч зарим бэрхшээлүүдтэй тулгарч байв.
  - Нэгдүгээрт, инфляцийг хоёр оронтой тооноос бага түвшинд авчрахад хүндрэлтэй байсан.
  - Хоёрдугаарт, Чехийн эдийн засагт шилжилт явагдаж байсны зэрэгцээ бүтцийн болон институцийн өөрчлөлт нь төгс бус шинжтэй байсан.
  - Гуравдугаарт, Чехийн эдийн засаг гадаад худалдаанд тулгуурлагдаг байсан учраас валютын ханш болон гадаад шок дотоодын үнийн түвшинд голлох нөлөө үзүүлдэг байв.

# Монгол улсын макро эдийн засгийн тойм

- Дэлхийн эдийн засгийн хямрал эдийн засагт хүчтэй нөлөөлсөн хэдий ч маш хурдтай сэргэж байна.
- Инфляцийн дарамт нэмэгдэж байна.
- Сүүлийн хоёр жилийн туршид мөнгөний бодлогын бүтэц хүчирхэгжиж байна.
- 2011 оны макро эдийн засгийн тогтвортой байдал дахь сангийн бодлогын зардлын төлөвлөгөө.
- Байгалийн баялагт түшиглэсэн эдийн засаг.

Эх сурвалж: (International Monetary Fund, 2011)


# Урьдач нөхцөлийн ШИНЖИЛГЭЭ

- *Институционал бие даасан байдал*
  - Төв банкны тухай одоогийн хуулинд тодорхойлсноор мөнгөний бодлогын эцсийн зорилтыг үнийн болон ханшийн тогтвортой байдлыг хангах гэж тайлбарлаж болохоор байгаа
  - Бие даасан бус байдал – улс төрийн болон төсвийн дарамт
  - Мэдээлэл дутмаг
- *Техникийн нөхцлүүд*
  - Инфляцийн ирээдүйн утгыг прогнозлох үйл ажиллагааг Монголбанк 2007 оноос эхлүүлэн ажиллаж байна
    - SIMOM
    - Алдааны шинжилгээ
  - Цаашид энэхүү загварыг улам сайжруулах болон гэнэтийн шокуудын макро эдийн засагт үзүүлэх нөлөөллүүдийг сектор бүрээр өргөн хүрээнд харахын тулд бусад боломжит томоохон загваруудыг хөгжүүлэх

# Урьдач нөхцөлийн ШИНЖИЛГЭЭ

- *Эдийн засгийн нөхцөлүүд*
  - Макро эдийн засгийн ихэнх нөхцлүүд болох гадаад худалдааны нөхцөл сайжран, гадаадын шууд хөрөнгө оруулалт нэмэгдсэнээс гадаад худалдааны алдагдал буурч, төсвийн орлого нэмэгдэн төсөв ашигтай гарах болсон нь инфляцийг онилох мөнгөний бодлогыг амжилттай хэрэгжүүлэх нэг урьдчилсан нөхцөл бүрдэж буйг харуулж байна.
- *Санхүүгийн тогтвортой байдал*
  - Манай санхүүгийн системд банкууд давамгайлан сүүлийн жилүүдэд эрчимтэй хөгжиж байгаа хэдий ч цаашид олон улсын стандарт, зохистой хяналт шалгалтын практикийг нэвтрүүлэх, хууль эрх зүйн орчныг улам боловсронгуй болгох, санхүүгийн системийн эмзэг байдлыг судлах зайлшгүй шаардлагатай

# Урьдач нөхцөлийн шинжилгээ



# Дүгнэлт

- Мөнгөний бодлогын үйл ажиллагаа нь түүний шилжих механизмаар дамжин эцсийн зорилгодоо хүрч хэрэгждэг.
  - Хүүний түвшин
  - Хөрөнгийн үнийн суваг
  - Валютын ханшийн суваг
  - Мөнгө ба зээлийн нийт хэмжээ
- Манай улсын хувьд мөнгөний бодлогын гол зорилгыг төгрөгийн худалдан авах чадварыг бууруулахгүй байх хэмээн ойлгож болох бөгөөд, харах өнцгөөс шалтгаалан энэхүү зорилгод хүрэхийн тулд хэд хэдэн төрлийн мөнгөний завсрын бодлого явуулах боломжтой. Үүнд:
  - Инфляцийг онилсон мөнгөний бодлого
  - Мөнгөний үзүүлэлтийн өсөлтийг онилсон мөнгөний бодлого
  - Валютын ханшийг онилсон мөнгөний бодлого
  - Эцсийн зорилгоо заралдаггүй мөнгөний бодлого

# ДҮГНЭЛТ

- Монгол улсад тохирох мөнгөний бодлогын арга хэлбэр нь инфляцийг онилсон мөнгөний бодлого болох нь тодорхойлогдсон
  - Валютын ханшийг хөвөгч байлгахыг шаарддаг – зохицуулалттай хөвөгч валютын ханшийн систем
  - Өсөлтийг шаардлагагүйгээр хязгаарладаг – уул уурхайн хүлээгдэж буй өсөлт
- Энэ бол 2007 оноос Монголбанкнаас албан ёсоор зарлаад байгаа инфляцийг онилсон мөнгөний бодлого манай улсад хангалттай тохиромжтой гэдгийг баталж байна.
- Институционал бие даасан байдлын хувьд хангалтгүй, техникийн нөхцлүүдийн хувьд ахиж байгаа, эдийн засгийн нөхцлүүдийн хувьд бүрэлдсэн, санхүүгийн тогтвортой байдлын хувьд сайжруулах шаардлагатай байна.

# Анхаарал хандуулсанд баярлалаа

Сайн үйлс дэлгэрэх болтугай!



# АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЭХ СУРВАЛЖ

- Bank of England. (2011). CCBS Publications. Гаргасан 2011, Bank of England: <http://www.bankofengland.co.uk-aac>
- CERGE EI. (2011). Research. Гаргасан 2011, Center for Economic Research & Graduate Education - Economics Institute : <http://www.cerge-ei.cz/-aac>
- Fischer, S. (1993). The Role of Macroeconomic Factors in Growth. Journal of Monetary Economics.
- International Monetary Fund. (2011). Mongolia: Financial System Stability Assessment. IMF.
- International Monetary Fund. (2011). Publications. Гаргасан 2011, International Monetary Fund: <http://www.imf.org-aac>
- International Monetary Fund. (огноо байхгүй). Inflation Targeting in Practice.
- Loayza , N., & Hebbel, K. S. (2002). Monetary Policy Functions and Transmission Mechanisms: An Overview. Central Bank of Chile.
- Mishkin, F. S. (2010). The Economics of Money, Banking & Financial Markets. The Addison-Wesley Series in economics: Pearson.
- The National Bureau of Economic Research. (2011). Working Papers & Publications. Гаргасан 2011, the NATIONAL BUREAU of ECONOMIC RESEARCH: <http://www.nber.org-aac>
- Walsh, C. E. (2010). Monetary Theory and Policy. Cambridge: The MIT Press.
- Бумчимэг, Г. (2004). Мөнгөний бодлогын зорилтын сонголт, үр дүнг үнэлэх, хэрэгслүүдийг сонгох, бодлогыг хэрэгжүүлэх, онол практикийн асуудлууд. Улаанбаатар: Монголбанк.
- Ган-Очир, Д. (2007). Мөнгөний бодлогын хэлбэрүүд. Улаанбаатар: Монголбанк.
- Монголбанк. (2011). Мөнгөний бодлого. Bank of Mongolia: <http://www.mongolbank.mn-ээс> Гаргасан
- Монголбанк. (2011). Төрөөс мөнгөний бодлогын талаар 2012 онд баримтлах үндсэн чиглэлийн төсөл. Улаанбаатар: Монголбанк.
- Сноудон, Б., & Вэйн, Х. Р. (2010). Орчин үеийн макроэкономикс. Edward Elgar.
- Энхзаяа, Д. (2008). Монгол улсад инфляцийг онилох мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх нөхцөл, боломж. Улаанбаатар: МУИС-ЭЗС.